



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А1331

Номгон

Сав газрын талуудын оролцооны зөвлөлийн 7
үйл ажиллагааг дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/54 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 3.1.7 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Сав газрын талуудын оролцооны зөвлөлийн хурлыг 2023 оны 06 дугаар сарын 20-25 ,11 дүгээр сарын 15-20-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Сав газрын талуудын оролцооны зөвлөлийн хурлыг үр дүнтэй зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж, тайланг нэгтгэн Засаг даргад танилцуулах, холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Бөөнцагаан нуур-Байдраг голын сав газрын талуудын оролцооны зөвлөлийн дарга (Х.Баянмөнх), Орог нуур-Түйн голын сав газрын талуудын оролцооны зөвлөлийн дарга (Г.Энхбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Сав газрын талуудын оролцооны зөвлөлийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах 10,000,000 (Арван сая) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э. Ганзориг)-т зөвшөөрсүгэй.

4.Сав газрын талуудын оролцооны зөвлөлийн үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллахыг Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа (Б.Ням-очир)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хянал тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

642310821